



ЭНЭТХЭГ, МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН ХОЛБОО, ХАРИЛЦАА

*Философийн шинжлэх ухааны доктор,
профессор Д.Даашнүрэв*

Монголын философийн түүх бол нэгд, өвөг монголчуудын философийн үзэл санаа; хоёрт, монголын буддист философийн түүх; гуравт, монголын марксист, ленинист буюу коммунист философийн түүх; дөрөвт, монголын ардчилсан тогтолцооны үеийн либералист философийн түүх гэж хуваагдана. Харин Энэтхэг ба Монголын философийн холбоо, харилцааны асуудал монголын буддист философийн үед илүү ихээр яригдах бололцоотой юм.

Буддын шашин бол Энэтхэгийн соёл, иргэншил, нийгмийн үзэгдэл бөгөөд Азийн ард түмний дунд ихэд дэлгэрсэн юм. Үүгээр дэлхийн буддын шашинт орны соёл иргэншил буй болсон бөгөөд энэхүү хүрээнд Монгол үндэстэн нэгэн адил татагдан орсон билээ. Энэ үйл явцад шашин төдийгүй Энэтхэгээс үүсэлтэй философийн ухаан, философийн зохиол бүтээлүүд Монгол оронд нэвтрэн дэлгэрсэн түүхэн үйл явц өрнөж байжээ. Үүнийг эрдэмтэд ихэд судалсан бөгөөд чухамдаа буддизм монголд дэлгэрснийг наал зах нь гурван их үед хуваан үзэж болох шинжтэй. Тухайлбал; Нэн эртний буддын шашин хийгээд буддизм монголчуудын дээд өвөг болох хүннүчүүдийн байгуулсан Хүннүгийн их гүрний үед монгол газар оронд дэлгэрч асан ул мөр хэдийгээр гун бүдэг ч асан бий бололтой. Харин энэ тухай нүүдэлчин монголчуудын нэг гол угсаатан болох боржгины язгууртан Чингис хааны овог угсааны түүх гэгдэх “Нууц товчоо”-нд дурьдагдсан зүйл байгаа юу?

Мэдээж тэнд бөөгийн ёсны ойлголт, үзэл санаа, философийн зарчмууд нилээд тодорхой тусгагдсан байдаг. Мөн эртний хятадын бумбын ёсны мэргэдийн нэгийг эзэн Чингис хаан урин уулзаж асан тухай мэдээ буй. Түүнчлэн араб дахины соёл, иргэншлийн хүрээний зарим улсыг байлдан эзэлж агсан тул лалын ёсны талаар ерөнхий мэдээлэл байгаа. Бас монгол угсааны зарим овог аймаг христосын ёсны эртний урсгалуудын нэгийг дагаж агсан тухай мэдээ байгаа. Гэтэл энэхүү XII ба XIII зууны үед дэлхийд ихэд түгэл дэлгэрээд агсан буддизмын тухай тэр үеийн монголчууд ямарваа ойлголтгүй байсан юм болов уу? Гэвч Чингис хааны цэргийн зарим хэсэг дайснаа хөөн мөшгиж явсаар хойт энэтхэг хүрсэн удаатай. Тэгээд ч Энэтхэгийн талаар багагүй мэдээлэл, тодорхой ойлголттой байсан тухай “Нууц товчоо”-нд өгүүлсэн зүйл байдаг. Хэдий тийм боловч монголд буддизм, түүний үзэл санааны тулгуур зарчмууд илэрхий дэлгэрч эхэлсэн нь Өгөөдэй хааны үеэс юм.

Монголд буддизм дэлгэрсэн нь Монгол-Энэтхэгийн соёлын харилцааны чухал үйл явдал билээ. Ялангуяа олон ухааны алдарт цоморлиг болсон Ганжуур, Данжуур хийгээд Энэтхэгийн авьяас билэгт мэргэд, Нагаржунай, Арьяандэв, Васубанди зэрэг эртний болон дундад эртний буддын томоохон сэтгэгчдийн бүтээл Монгол оронд түгэн дэлгэрч өнөөг хүртэл бүрнээрээ хадгалагдаж байгаа юм. Эдгээрийн дотор эдүгээ уг эх санскрит хэлээрээ хадгалагдаж ирээгүй үрэгдсэн зарим судар, шаштир цөөнгүй байна. Энэ бол нүүдэлчин Монголчуудаас хүн төрөлхтөний соёлын өв хөгжилд оруулсан чухал хувь нэмэр төдийгүй Энэтхэг Монголын соёлын харилцааны чухал ололт гэж үзэх боломжтой.

Түүнээс гадна Энэтхэг-Монголын философийн харилцаанд зайлшгүй авч үзэх ёстой асуудал бол Энэтхэгийн уламжлалт соёл, шинжлэх ухаан, философийн олон зохиолыг орчуулж хэвлэсэн нь монголчуудын оюуны сан хөмрөгийг дорнын их ухаанаар баяжуулсан гэж үзэж болно. Түүнчлэн эдгээр орчуулга нь Монголын сонгодог бичгийн найруулга бүрэлдэн тогтоход нөлөөлсөн төдийгүй Монгол орноо дэлгэрсэн их хөлгөний ёс, түүний философийн үндэслэлийг нэн нарийнаар гүнзгийрүүлэн судлах үндсийг тавьж өгсөн байна..

Монгол-Энэтхэгийн шашин, философийн харилцаанд үлэмжийн нөлөө үзүүлсэн нэн сонирхолтой баримт бол монголчууд хэдэн зуун жил Төвдөөр дамжин Энэтхэгт эрдэм боловсрол эзэмшиж байсан явдал юм. Тэр ч байтугай түүхийн зарим нэг бүдэг боловч сурвалжаас үзвэл манай эриний V зууны үед Энэтхэгийн номын их хүрээлэн Наландарын хийдийн буддын философийн сургуульд Солонгос, Монголын залуус суралцаж байсан мэдээ буй.

Монголын их сэтгэгч Заваа Дамдин “Алтан дэвтэр” зохиолдоо “Тэр цагт монгол хүмүүс ном хурахдаа Энэтхэг хэлээр хурах ба номлох, өөрийн хэлээр Энэтхэг үгээр нэмэрлэн орчуулах заншилтай байсан” гэсэн нь их сонирхолтой мэдээ юм. Энэтхэгийн мэргэд Монголд залагдан шашин, философийн номонд тус бүтээх, мөн монгол лам нар ч Энэтхэг газар хүрч таван ухааны номд суралцан бандида болж ирээд шашны ёс, философийг дэлгэрүүлж байсныг Монголын мэргэд Монголд бурхны шашин дэлгэрсэн нь буюу “Хор чойнжун” хэмээх шашин номын түүхэн зохиолдоо дурдсан байдаг билээ. Энэ бол эртнээс Энэтхэг Монголын харилцаа, тэр дундаа, соёл, шашин, философийн харилцаа, холбоо байсныг харуулсан хэрэг мөн.

Үүний хамт 18-19-р зууны үед Төвд Самгарид хэл монголчуудын дунд өргөн дэлгэрч улмаар шашин мөргөлийн хэл төдийгүй философийн мэдлэгийн хэлний үүргийг гүйцэтгэж байжээ. Эдгээр нь бүхэлдээ хоёр ард түмний харилцаа өнө эртнээс уламжлалтай, нэн ялангуяа бурхны шашны төвд хэлбэрийн соёл иргэншил Монголд нэвтэрсэн үеэс Энэтхэгийн философийн уламжлал Төвдөөр дамжин Монголчуудын оюуны соёлд гүн нөлөө үзүүлж байсныг харуулж байгаа билээ.

Монгол-Энэтхэгийн философийн харилцааны салбарт гарч байсан сонирхолтой үзэгдэл бол Монголын сэтгэгчдээс буддын философийн онол, үзэл санаа, эх сурвалжийг судалж, монгол сэтгэлгээний өв уламжлал болгон хөгжүүлж ирсэн явдал мөн. Тухайлбал, Монголын мэргэд Энэтхэг дэх буддын философийн түүх, түүний эх сурвалжаар нь хөөн судалж гол эх зохиолд тайлбар хийх, бэрх хатуу үгийн толь бичиг зохиох замаар нягтлан шинжилж байжээ. Энэ нь монголын философийн сэтгэлгээний чухал өв болон

үлдсэн юм. Энэ нь яваандаа монголчуудын онолын сэтгэлгээний нэг уламжлалт хэв шинж болсон гэж хэлэхээр байгаа юм. Тийм ч учраас ХХ зуунд монголын философчид коммунист философид зөвхөн тайлбар, тайлбарласан баяжуулалт, нөхөн гүйцээх оролдлого зэргийг хийж байсан ажгуу. Энэтхэгийн философийн чиглэлээр ном зохиол туурвиж, ном зохиолд зүүлт тайлбар хийж, түүнийг гүнзгийрүүлэн боловсруулахад үнэт хувь нэмэр оруулсан олон эрдэмтэд Монгол орноос төрөн гарчээ. Ийм сэтгэгчдийн тоонд халхын Зая Бандид Лувсанпэрэнлэй /1642-1715/, дээд монголын эрдэмт хамба Ишбалжир /1704-1788/, Алша Лхарамба Агваандандар /1759-1842/, номун хаан Агваан Хайдав /1770-1838/ зэрэг сэтгэгчдийг дурьдаж болно.

Ер нь буддын мэдлэг ухааны нэг болох философийн ухаанаар 300 шахам сэтгэгчид судалгаа хийж, түүнийг цаашид хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байжээ. Нөгөөтэйгүүр Энэтхэгээс уламжлалтай буддын философи Монгол сэтгэлгээгээр баяжигдан, монгол хөрсөнд төлжиж чадсан юм. Энэ бол эртний Энэтхэгийн соёлд, ялангуяа энэтхэгийн философийн уламжлалд оруулсан монголчуудын хувь нэмэр гэж үзэж болно.